



Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа
БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

(2026 оны 05 дугаар сар)

ГАРЧИГ

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ V САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН .3

1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ.....	3
1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил.....	3
1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад хүргэсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол	3
1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд үзүүлсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол	4
1.1.3. Нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүлийг дэмжих чиглэлээр хүргэсэн үйлчилгээ	5
1.1.4. Ур чадвартай ажилчны (Е-7-4) виз руу шилжихийг дэмжих үйлчилгээ	6
1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр)	7
1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо	7
1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт	7
1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт	7
ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ.....	9
2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ.....	9
2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажлын хүрээнд.....	9
2.3. Зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ.....	9
2.4. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр)	10
ГУРАВ. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ЯВУУЛЫН БОЛОН СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ.....	12
3.1. Сургалт сурталчилгаа, явуулын болон сэтгэл зүйн үйлчилгээ	12
3.2. Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ	14
3.3. Хамтын ажиллагаа, төвийн зарим дотоод ажил	15

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ V САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үйл ажиллагаа нь Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, хоёр улсын холбогдох яамдын хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хэрэгждэг.

Тус төв нь БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээг, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай төрийн үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага юм.

2026 оны V сард төвийн дүрэм, хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, эрхлэх асуудлынхаа хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, иргэдэд хүргэсэн төрийн үйлчилгээг (хөдөлмөр, нийгмийн хамгаалал болон нийгмийн даатгалын чиглэлээр ангилж) энэхүү тайланд дурьдав.

1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

(Тайлант хугацаа 2026.05.01 - 2026.05.31)

1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2026.05.01-2026.05.31-ний өдрийг хүртэлх хугацаанд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт **490** иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд болон холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээ үзүүлж, өргөдөл гомдлыг шийдвэрлэн ажиллав.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын Самсунг даатгалын оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал: 35,772,230 вон, нутаг буцах зардал: 3,099,240 вон, ажил олгогчоос олгох 13 дахь сарын цалингийн зөрүү: 14,619,204 вон, олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс: 9,654,720 вон зэрэг хэлбэрээр нийт **66,477,394** воныг Монгол Улсын **32** иргэнд (давхардсан тоогоор) олгуулав.

1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад¹ хүргэсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол

- Иргэн Ж.Н-ийн (Е-9) 13 дахь сарын цалин 13,442,478 вон, нутаг буцах замын зардал 500,000 вон, нийт 13,942,478 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан.

¹ Албан хэрэгцээнд зориулсан тайланд тус төвөөс үйлчилгээ авсан иргэний нэрийг тодорхой дурьдсан болно. Төвийн албан ёсны вэб хуудсаар дамжуулж олон нийтэд нээлттэй мэдээлдэг тайланд иргэний нэрийг товчлон дурьддаг болохыг анхаарна уу.

- Иргэн А.У-гийн (Е-9) 13 дахь сарын цалин 7,281,351 вон, нутаг буцах замын зардал 500,000 вон, нийт 7,781,351 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн Ц.Т (Е-9) нь нутаг буцах болсон тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж 6,080,561 воныг хилээр гарахад нь бэлнээр олгуулсан.
- Иргэн Г.А (Е-9) нь нутаг буцсан тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж, 13 дахь сарын цалин 1,913,840 воныг олгуулсан.
- Иргэн О.Т-гийн (Е-9) Самсунг даатгалаас авах 13 дахь сарын цалин 7,054,000 вон болон нутаг буцах замын зардал 523,500 воныг олгуулан ажиллав.
- Иргэн А.Э (Е-7) нь визний ангиллаа сольсон тул холбогдох баримтыг бүрдүүлэн Самсунг даатгал руу илгээж, нутаг буцах зардал 512,180 воныг олгуулав.
- Иргэн Ж.Н-ийн (Е-9) 13 дахь сарын цалингийн зөрүү болох 3,211,051 воныг ажил олгогчоос нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн Э.Б-гийн (Е-9) олгогдоогүй цалин хөлс болох 3,651,710 воныг олгуулав.
- Иргэн Н.М-ийн (Е-9) олгогдоогүй хойшилсон цалин 1,430,000 воныг олгуулсан.
- Иргэн Б.Б-гийн ажил олгогч нь ажлын байранд дарамталсан асуудлаар хотод байрлах үйлдвэрийн байранд очиж, ажил олгогчтой уулзан асуудлыг тодруулав.
- Иргэн Х.А-гийн (Е-9) ажлын байр солих өргөдлийн дагуу ажил олгогчтой холбогдож, харилцан зөвшилцсөнөөр ажлын байр солих мэдэгдэл хийлгэв.
- Иргэн Б.Х-гийн (Е-9) ар гэрээс холбоо барьж чадахгүй байгаа тул холбоо тогтоож өгөхийг хүссэний дагуу Гэрээт ажилчдын нэгдсэн мэдээллийн сангаас мэдээллийг шүүж, ажил олгогчтой холбоо барин, мэдээлэл солилцсон.

1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд үзүүлсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол

- Иргэн Ц.Д нарын 10 хүний (оюутан, визгүй) олгогдоогүй цалин хөлсний маргааныг хүлээн авч, ажил олгогчтой тохиролцон 4,722,780 воныг олгуулсан.
- Иргэн С.О (визгүй) нь үйлдвэрлэлийн осолд өртсөн ба ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг ажил олгогчоос нэхэмжлэн 3,332,000 воныг олгуулав.
- Иргэн М.М-ийн (визгүй) үйлдвэрт 2023.05.01-2026.03.27 хүртэл ажилласан хугацааны үйлдвэрээс авах 13 дахь сарын цалинг нэхэмжлэн Чонан хотын Хөдөлмөрийн хэлтэст өргөдөл гаргаж, 7,756,443 воныг олгуулсан.
- Иргэн Б.Г-д (G-1) “Марина бэй” зочид буудалд ажилласан хугацааны олгогдоогүй цалин 2,536,940 воныг нэхэмжлэн олгуулав.
- Иргэн Б.Б-гийн (визгүй) махны үйлдвэрт ажиллаад авч чадаагүй цалингийн үлдэгдэл 535,000 воныг ажил олгогчоос нэхэмжлэн олгуулав.
- Иргэн М.Б (визгүй) нь барилгын нураалтын ажил хийж байгаад баригдаж нутаг буцсан бөгөөд ажилласан хугацааны олгогдоогүй цалин хөлс 430,000 воныг олгуулав.
- Иргэн Ц.Т-гийн (визгүй) хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байхдаа төлсөн нутаг буцах зардлыг Аж үйлдвэр, хүний нөөцийн хэрэг эрхлэх газраас (서울남부지사) нэхэмжилж 547,410 воныг дансанд нь олгуулсан.

- Иргэн Б.Б-гийн (G-1) нутаг буцах зардал 516,150 воныг Аж үйлдвэр, хүний нөөцийн хэрэг эрхлэх газраас нэхэмжлэн олгуулсан.
- Иргэн Г.Г, Г.Б нарын олгогдоогүй цалин хөлсний өргөдлийг хүлээн авч, өргөдлийн бүрдүүлбэрийг бүрдүүлж байна.
- Иргэн Э.Ч-гийн (визгүй) олгогдоогүй цалин хөлс 300,000 вон олгуулах хүсэлтийг хүлээн авч өргөдлийг шилжүүлэхээр ажиллаж байна.
- Иргэн А.Б-гийн (визгүй) Үжинбү хотын Хөдөлмөрийн хэлтэст (고용노동부 의정부고용노동지청) гаргасан өргөдөл нь “Хөдөлмөр эрхэлсэн байдал тогтоогдоогүй” гэх үндэслэлээр буцаагдсан бөгөөд өргөдөл гаргагчийн хүсэлтээр өргөдлийг хаасан.
- Иргэн Б.Ц-гийн (G-1) олгогдоогүй цалингийн үлдэгдэл 3,900,000 воныг олгуулахаар Хөдөлмөрийн хэлтэст (대구서부고용노동지청) өргөдөл гарган нэхэмжилсэн ба 2026.04.14-ний өдөр 500,000 вон, 2026.04.30-ны өдөр 1,700,000 воныг олгуулсан. Үлдэгдэл 1,700,000 воныг олгуулахаар ажиллаж байна.
- Иргэн Б.Б-гийн (хууль бус) үйлдвэрт машинистаар ажиллаад авч чадаагүй цалингийн үлдэгдэл 1,413,000 воныг олгуулахаар өргөдлийн бүрдүүлбэрийг бүрдүүлэн ажиллаж байна.
- Иргэн Б.А-гийн (F-3) үйлдвэрээс авах 13 дахь сарын цалин 8,119,294 воныг олгуулахаар Хөдөлмөрийн хэлтэст (경기고용노동청) 2026.05.15-ны өдөр өргөдөл гарган нэхэмжилсэн.
- Д.А-гийн (визгүй) үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн өргөдлийг Хөдөлмөрийн хэлтсээс шалгаж үзээд, цалингийн лавлагааны бичиг гаргаж өгсөн ба дараагийн шатны арга хэмжээ авахаар холбогдох баримтыг бүрдүүлэн ажиллаж байна.
- Иргэн Д.Д, Б.О, А.Б нарын газар ажиллаад авч чадаагүй цалингийн өргөдлийг хүлээн авч, холбогдох баримтыг бүрдүүлж байна.
- Иргэн Д.Б (визгүй), Б.Г (визгүй), Ч.Г (визгүй), С.Т (визгүй), Ц.Т (визгүй), Д.О (визгүй), С.М (визгүй) нарын сайн дураар нутаг буцах мэдэгдлийг Цагаачлалын албанд гаргаж, баталгааны хуудсыг өргөдөл гаргагчид илгээв.

1.1.3. Нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүлийг дэмжих чиглэлээр хүргэсэн үйлчилгээ

- Иргэн Ш.Б-гийн (хүү Г.О оноштой) халамжид хамрагдах хүсэлтийн дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссоор оруулж “Байнгын асаргаа шаардлагатай” болохыг жилээр тогтоолгон халамжид хамруулсан.
- Иргэн Б.Т-гийн (хүү Б.Т оноштой) халамжид хамрагдах хүсэлтийн дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссоор оруулж “Байнгын асаргаа шаардлагатай” болохыг ... жилээр тогтоолгон халамжид хамруулав.
- Иргэн Д.Т (C-3) визээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэйгээ ирсэн бөгөөд КИМС хүүхэд хөгжлийн эмчид үзүүлэх хүсэлтийн дагуу эмчтэй уулзуулж, оношилгоо хийлгэн, дүгнэлтээ авч, нөхөн сэргээх эмчилгээ авахад дэмжиж туслав.

- Иргэн Б.Б-г охины хамт их сургуулийн эмнэлгээс гарахад тусалж, тухайн иргэний хүсэлтээр ... байгууллагад хүсэлтийг нь албан бичгээр уламжилж ажиллав.
- Сөүл хотод 2026.05.08-ны өдөр зохион байгуулагдсан “Би Монгол” хүүхдийн анхдугаар чуулганы үйл ажиллагааг дэмжиж оролцсон.
- Монгол хэл бичгийн сургалтыг төвийн байранд ням гараг бүр зохион байгуулж байна.
- 2026.05.30-ны өдөр Монголын эмэгтэйчүүдийн холбооны БНСУ дахь салбар Зөвлөлтэй хамтран анх удаа 1000 хүүхдийн баярыг амжилттай зохион байгуулсан.

1.1.4. Ур чадвартай ажилчны (Е-7-4) виз руу шилжихийг дэмжих үйлчилгээ

- Хөдөлмөрийн гэрээт ажилчны Е-9 визээс ур чадвартай ажиллах хүчний Е-7-4 виз руу шилжсэн иргэдийн судалгаанд тайлант хугацаанд 2 иргэнийг, Е-7-4 виз руу шилжих хүсэлтэй болон хугацааны болзол хангасан иргэдийн судалгаанд 18 иргэнийг шинээр бүртгэсэн.
- Е-7-4 визний асуудлаар нийт 54 иргэнтэй утсаар болон цахимаар холбогдож бүрдүүлэх баримт бичиг, оноо тоолох, гэр бүлээ урих, ТОПИК шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэх, жолооны үнэмлэх авах, ажлын байр солих, D-10, F-2, E-7-4R, F-2R ангилал руу өөрчлөх зэрэг асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгсөн.
- Иргэн Ц.М-ийн визийг Цагаачлалын албанд мэдүүлсэн.
- Иргэн Г.Б-гийн мэдүүлсэн виз 2026.05.19-ний өдөр зөвшөөрөгдөж Е-7-4 визтэй болсон.
- Ур чадвартай ажилчны Е-7-4 визний талаар цахим сургалтыг зохион байгуулах талаар зарыг 240 иргэнд масс мессежээр хүргэж, 2026.05.17-ны өдөр цахимаар зохион байгуулсан ба 21 иргэнд мэдээлэл өгсөн.
- Е-7-4 визний асуудлаар “Е-7-4 визний мэдээлэл солилцох групп” сошиал групп үүсгэн визээ сольсон, солих хүсэлтэй иргэдийг нэгтгэж байгаа ба гишүүдийн тоо 1101 байна. Мэдээлэл сурталчилгааг идэвхжүүлэх зорилгоор тус сошиал хуудсанд дагалдан визний журамд өөрчлөлт орсон тухай, ажиллах эрхтэй визний тухай, солонгос хэлний ажилд хэрэгтэй үг хэллэгүүд зэрэг 21 удаагийн мэдээлэл зөвлөгөөг нийтэлсэн.

1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр)

1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо

Тоон мэдээллийн агуулга		Гүйцэтгэлийн тоон үзүүлэлт	
		Иргэн	Олгуулсан дүн (вон)
Хөдөлмөрийн гэрээт ажилчдад	1. Нутаг буцах зардал	6	3,099,240
	2. Цалин, илүү цагийн хөлс	1	1,430,000
	3. Самсунгийн 13 дахь сарын цалин	5	35,772,230
	4. Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү мөнгө	2	6,862,761
	5. Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	6. Гэнэтийн ослын даатгал		
	7. Гэнэт халагдсаны тэтгэмж		
	8. Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
Бусад төрлийн визээр оршин суудаг иргэдэд	9. Олгогдоогүй хойшилсон цалин хөлс	2	2,536,940
	10. 13 дахь сарын цалин		
	11. Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	12. Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
Хууль бусаар оршин суудаг иргэдэд	13. Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	13	5,687,780
	14. 13 дахь сарын цалин	1	7,756,443
	15. Үйлдвэрлэлийн ослын даатгал	1	3,332,000
	16. Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад	2	
Нийт олгуулсан мөнгөн дүн/иргэн		32	66,477,394

1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт

Нийт өргөдөл	Шинээр хүлээн авсан өргөдөл	Шийдвэрлэлтийн байдал			
		Хугацаанд нь шийдвэрлэсэн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Шийдвэрлэж буй
73	36	20	37	-	16

1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт

Үйлчилгээний төрөл	Тоо
1. Самсунг даатгалын газраас 13 дахь сарын цалин болон нутаг буцах замын зардал авах материалыг бүрдүүлэн, даатгалыг олгуулах,	16
2. нутаг буцахтай холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх	
3. Үйлдвэрээс авах 13 сарын цалингийн зөрүү бодолт хийх аргачлалыг танилцуулах, бодолт хийх, ажил олгогчоос нэхэмжлэн олгуулах	13
4. Гэрээт ажилчдын ажлаас гарах өргөдөл гомдлын дагуу судлан, асуудлыг шийдвэрлэх	20
5. Олгогдоогүй цалин хөлсний маргааныг шийдвэрлэж, цалин, хөлсийг олгуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх	33

6. Цалин, илүү цаг, амралтын хөлсийг бодох болон тооцоолох аргачлалын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	2
7. Үйлдвэрлэлийн ослын тухай, осолд орсон иргэнийг ослын даатгалд хамруулж, ажилгүйдлийн тэтгэмж болон нөхөн олговрыг олгуулах	3
8. Гэнэтийн ослын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, даатгалд хамруулж, нөхөн олговрыг олгуулах	
9. Үндэслэлгүй болон ажил олгогчийн буруутай үйлдлээс шалтгаалан ажлын байр солих болон гэнэт халагдсан тохиолдолд бүрдүүлэх материал, гэнэт халагдсаны тэтгэмж, бусад тэтгэмжийг олгуулж, өргөдлийг шийдвэрлэх	1
10. Хөдөлмөрийн гэрээ сунгах (1жил 10сар), тусгай болон тогтвортой нөхцөлөөр дахин ирэх, давтан гэрээ байгуулахтай холбоотой бүх төрлийн мэдээлэл, зөвлөгөө өгөх	7
11. Бүх төрлийн аман болон бичгийн орчуулгын үйлчилгээ. Үүнд: БНСУ-ын Засгийн газрын байгууллага, Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, Хөдөлмөрийн хэлтэс, Төв бирж, Эрүүл мэндийн газар, Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв, Үндэсний тэтгэврийн алба, Хөдөлмөр, халамжийн газар (Хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагатай холбоотой аман болон бичгийн орчуулга)	29
12. Хөдөлмөрийн гэрээт иргэдийн хамрагдах даатгал (ЭМД, ГОД, ҮОД, НД)-ын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	1
13. Жилийн эцсийн тайлангаар ХАОАТ-ын буцаалт хэрхэн авах талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	
14. Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх газар (ХЭХЯ), Шүүхийн шатанд өргөдөл, гомдол гаргах асуудлыг шийдвэрлэх, Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв, Хөдөлмөр халамжийн корпорац, Сөүлийн баталгаат цалингийн даатгалын газарт иргэний өргөдлийг дамжуулан өгч шийдвэрлэх	2
15. Монгол иргэдийн сайн дураар нутаг буцах мэдэгдэл гаргах, оршин суух хугацааг шалгах, сунгах хүсэлт гаргах, цаг авахад туслах	1
16. Визний ангилал солиулахад (Е9-өөс Е-7-4 виз рүү) оноо цуглуулах, топик шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэх талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	54
17. Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх	65
18. Бусад мэдээлэл, зөвлөгөө	200
19. ХурДан төрийн цахим үйлчилгээ үзүүлэх	31
Үзүүлсэн үйлчилгээний тоо	Утсаар 339
	Цахимаар 86
	Танхимаар 58
Нийт	490

ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

(Тайлант хугацаа 2026.05.01 - 2026.05.31)

2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа болон бусад хэлбэрээр ажиллаж, амьдарч байгаа иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар хамруулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх арга хэмжээ:

- 1) Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй иргэдээс 24 иргэнийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.

❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:

- 24 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
- 4 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
- 20 иргэнд шинээр гэрчилгээ олгосон.

Нийт 48 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.

- 2) БНСУ-д бусад төрлийн визтэй оршин суугч Монгол иргэдээс 28 иргэнийг сайн дурын даатгалд хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.

❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:

- 23 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
- 3 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
- 15 иргэнд шинээр гэрчилгээ олгосон.

Нийт 41 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.

2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажлын хүрээнд

Тайлант хугацаанд тус тасаг 279,931,763.61 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн бөгөөд орлогын сарын төлөвлөгөө 65 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шимтгэлийн 106,559,294.94 төгрөгийн орлогыг БНСУ-ын 3 банкны сангийн харилцах данснаас Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төрийн банкин дахь төвлөрүүлэх дансанд бүрэн шилжүүлж, сарын мэдээг хуульд заасан хугацаанд гаргасан. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хуульд тус тус заасны дагуу тайлан, мэдээллийг Сангийн яамны холбогдох мэдээллийн санд байршуулсан.

2026 оны 05 дугаар сард нийт 76 даатгуулагчийн 3 болон түүнээс дээш сарын 65,395,428.00 төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулсан. Үүнд, албан журмын даатгалын 49 даатгуулагчийн 35,353,200.00 төгрөг, сайн дурын даатгалын 27 даатгуулагчийн 31,042,228.00 төгрөг байна.

2.3. Зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ

БНСУ-д амьдарч буй иргэд болон хөдөлмөрийн гэрээт иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, өргөдөл гомдлыг шийдвэрлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ:

- 1) Тайлант хугацаанд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах, орчуулга хийх зэрэг зөвлөгөө мэдээллийг утас (320), цахим (26),

танхим (120)-аар нийт 466 иргэн, даатгуулагчид үйлчилсэн.

- 2) БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар ирүүлсэн 5 иргэний 17,527,820 вон нэхэмжилсэн хүсэлтийг холбогдох бичиг баримтын хамт тус улсын Үндэсний тэтгэврийн албанд хүргүүлсэн. БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албанаас 6 ээлжийн 28 иргэний 131,253,410 воны буцаан олголтыг шийдүүлж, иргэдэд олгуулсан.
- 3) 2026.05.02-нд БНСУ-ын Инчеон хот дахь сургалтын төвд Е-9 визээр БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирж буй 23 иргэнд Нийгмийн даатгалын тухай ойлголт, өөрийн орны тэтгэврийн даатгалд хамрагдаж, ирээдүйн нийгмийн баталгаагаа хангах, тэтгэврийн даатгалын шимтгэлийг БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд давхар төлөхгүй, тус улсын хуулийн дагуу заавал хамрагдах тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх боломж, Солонгос улсын Үндэсний тэтгэврийн албанд төлсөн шимтгэлийг нь буцаан олгох тухай, Сайн дурын даатгалын гэрээг хэрхэн байгуулах тухай сургалт зохион байгуулж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.
- 4) 2026.05.29-ний өдөр БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Монгол Тауны гадна талбайд зохион байгуулж тус өдөрлөгөөр Нийгмийн даатгалын тухай ойлголт, сайн дурын даатгалд хэрхэн хамрагдах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, жирэмсний болон амаржсаны амралт эдлэх, ажилгүй болоход өөрт нь, хэрэв даатгуулагч нас барвал түүний асрамжид байсан гэр бүлийн гишүүнд тэтгэвэр, тэтгэмж олгох төлбөрийн тухай 31 иргэнд заавар зөвлөгөө өгч, 120 ширхэг тараах материал тараасан.
- 5) БНСУ-д оршин сууж байгаа Монгол Улсын иргэдийн амьдарч оршин суух нөхцөл, ажил эрхлэлт, нас хүйс болон нийгмийн даатгалд даатгуулсан байдал, нийгмийн даатгалын талаарх ойлголтыг тодорхойлох судалгааг 60 иргэнээс авсан.
- 6) Байгууллагын үйл ажиллагааг таниулах, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор сар бүрийн сүүлийн 7 хоногийн 5 дахь өдөр болон Монгол тауны 2 давхарт 7 хоног бүрийн 2, 4 дэх өдөр холбогдох мэргэжилтнүүд хуваарийн дагуу ажилласан.

2.4. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр)

Үйлчилгээ		Тоо	Өссөн дүнгээр
1. Даатгалд шинээр хамруулсан	Албан журмын даатгал	24	190
	Сайн дурын даатгал	28	224
2. Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон (Албан журмын даатгал)	Шинээр	20	176
	Дахин	4	18
	Хугацаа сунгасан	24	142
3. Үндэсний тэтгэврийн даатгалаас	Шинээр	15	100
	Дахин	3	25

чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон (Сайн дурын даатгал)	Хугацаа сунгасан	23	145
4. Шимтгэлийн орлого төвлөрүүлэлт	Албан журмын даатгал	99,314,100 23%	540,879,400.00 42%
	Сайн дурын даатгал	180,617,663.61 104%	862,444,601.61 94%
	Нийт	279,931,763.61 65%	1,403,324,001.00 63%
5. Гурав болон түүнээс дээш сарын шимтгэлийн авлага барагдуулалт	Албан журмын даатгал	35,353,200	164,435,928,00
	Сайн дур	31,042,228.00	118,482,513.00
6. БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын буцаан олголт	Нэхэмжилсэн	17,527,820,00	58,606,090.00
	Олгосон	131,253,410	131,253,410
	Буцаан олголт авсан хүний тоо	28	28
7. Иргэдэд өгсөн зөвлөгөө, мэдээлэл	Утсаар	320	1,683
	Цахимаар	26	148
	Танхимаар	120	336

ГУРАВ. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ЯВУУЛЫН БОЛОН СЭТГЭЛ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ

3.1. Сургалт сурталчилгаа, явуулын болон сэтгэл зүйн үйлчилгээ

Төвийн БНСУ дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” сошиал хуудсанд 44, youtube сувагт 6, байгууллагын seoulcenter.mlsp.gov.mn цахим хуудсанд 44 мэдээлэл, зөвлөгөө нийтэлж сурталчилснаар 247,086 хандалт авсан.

Байгууллагын сошиал хуудсаар дамжуулан БНСУ-ын холбогдох хуулийг сурталчлах, иргэдэд мэдээлэх зорилгоор “Хуулийн булан”-г нээж “Хөдөлмөрийн хуулийн үйлчлэх хүрээ”, “Ажлаас халах тухай урьдчилан мэдэгдэх”, “Эцгийн чөлөө буюу эхнэр төрөх, амаржсан үед олгох чөлөө”, “Ажлаас халахад тавигдах хязгаарлалт” сэдвээр цуврал мэдээлэл бэлтгэн иргэдэд хүргэв.

2026.04.24-ний өдөр төвийн албан ёсны мэдээллийг БНСУ-ын “Naver” платформд байршуулсан.

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирэх 17 иргэнд ирэхээс өмнөх сургалтыг 2026.05.08, 11-ний өдрүүдэд цахимаар, ирсний дараах сургалтыг 2026.05.14-ны өдөр үйлчилгээний болон аж үйлдвэрийн салбарт ажиллахаар ирсэн 36 иргэнийг хамруулан Ёжү болон Ичоны сургалтын төвд танхимаар тус тус зохион байгуулж дараах агуулгын хүрээнд мэдээлэл өгөв. Үүнд:

- ХНХҮТ-ийн үйл ажиллагааны танилцуулга
- Цалин хөлс тооцох, ажлын байр солих талаар
- Үйлдвэрлэлийн ослын даатгал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ослоос урьдчилан сэргийлэх тухай
- Солонгос улсын хууль, журам, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар
- Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйл
- Сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл
- Ур чадвартай ажиллах хүчний E-7-4 визний талаар
- Солонгос хэлний сургалт, урьдчилсан үнэлгээ хийх шалгалтуудын хуваарь
- Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу тал зэрэг болно.

2026.05.02-ны өдөр БНСУ-ын Чонжү хотноо зохион байгуулагдсан “Гэрээт иргэдийн хаврын фестиваль”-д оролцож, явуулын үйлчилсэн. Фестивалийн үеэр нийт 50 иргэнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааны гарын авлага, нийгмийн даатгалын танилцуулга материалыг түгээж, 9 иргэнд хөдөлмөрийн харилцаатай холбоотой зөвлөгөө, мэдээллийг хүргэсэн.

2026.05.05-ны өдөр Илсан хотод Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар, ХНХҮТ, Наму ТББ хамтран зохион байгуулсан үйл ажиллагаанд явуулын үйлчилгээ хүргэсэн. Энэ үеэр 4 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, 40 гаруй иргэнд танилцуулга, гарын авлага тарааж ажиллав.

Сөүл хотын Ганнам дүүргийн Энтер шүдний эмнэлэгт 2026.05.02-ны өдөр явуулын үйлчилгээ хүргэж 6 иргэнд хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгалын асуудлаар зөвлөгөө мэдээлэл өгч, сурталчилгааны материал 20 ширхгийг байршуулав.

Хөдөлмөрийн гэрээний (E-9) визээр БНСУ-д хөдөлмөр эрхэлж буй Монгол иргэдийнхээ нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, ажил олгогчийн санал бодлыг нь сонсох зорилгоор Сөүл хотын Дунхэсүсан (동해수산) үйлдвэрт 2026.05.12-ны өдөр ажилласан. Монгол иргэдийг олноор нь ажлын байраар хангаж, дэмжин ажиллаж байгаад талархал илэрхийлж 13 монгол ажилчинд хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал, ур чадвартай ажилчны визний асуудлаар

мэдээлэл өгөн, солонгос хэлний сурах бичиг, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны гарын авлага 38 ширхгийг түгээж ажиллав.

2026.05.08-ны өдөр Гёнгү аймгийн Ансон хотод байрлах “대성씨엠” мах, махан бүтээгдэхүүн савлах үйлдвэрт ажиллаж буй хөдөлмөрийн гэрээт 15 Монгол иргэнтэй уулзаж, ажлын байрны нөхцөл байдалтай газар дээр нь танилцсан. Иргэдээс ажлын нөхцөл байдлын талаар санал сэтгэгдлийг сонсож, төвийн үйл ажиллагааг сурталчлан ажилласан.

2026.05.14-ний өдөр Инчон хотын Согү дүүрэгт байрлах “DUOBACK” тавилгын үйлдвэрт ажиллаж буй хөдөлмөрийн гэрээт 3 Монгол иргэнтэй уулзаж, ажлын байрны нөхцөл байдалтай газар дээр нь танилцсан. Иргэдээс ажлын нөхцөл байдлын талаар санал сэтгэгдлийг сонсож, төвийн үйл ажиллагааг сурталчлан ажилласан.

“Solab Sofa Laboratory” үйлдвэрийн 2 хөдөлмөрийн гэрээт ажилчинтай ажлын байранд нь очиж уулзан, тулгамдаж буй асуудлын талаар санал солилцов.

Инчон хотын Намдун дүүргийн “Friends” зоогийн газар, Ёнсү дүүргийн Хурд 1,2,3 каргоны газарт 7 иргэнд байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаа болон хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав. Нийт 100 ширхэг орчим тараах материалыг зоогийн газар, каргоны газарт байршуулав.

2026.05.03-ний өдөр Үжинбү хотод зохион байгуулсан Солонгос дахь Монголчуудын “Хаврын Баяр 2026” наадамд нийгмийн даатгал, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав.

Элчин сайдын яамнаас зохион байгуулсан “Хариуцлагатай амьдарцгаа” аяны хүрээнд 2026.05.20-ны өдөр Ёнсэй их сургууль, 2026.05.21-ний өдөр Кореа их сургуулийн оюутан залууст зориулан “Гадаад оронд хэрхэн хурдан дасан зохицох вэ” сэдвээр сэтгэлзүйн сургалт хийж, төвийн танилцуулга мэдээллийг хүргэн, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгалын асуудлаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав.

2026.05.06-ны өдөр БНСУ-ын Улсан хотод байрлах БНСУ-ын Аж үйлдвэр, хүний нөөцийн хэрэг эрхлэх газартай хамтран “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн тогтолцоо”, “Гадаадын ажилтныг нэвтрүүлэх үе шат” сэдэвт сургалтыг зохион байгуулж БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн удирдлага болон албан хаагчдыг хамруулсан.

Зураг 2. Явуулын үйлчилгээ, үйлдвэртэй танилцах, сургалт зохион байгуулах үеэр







Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 вебинарт “Сөрөн тэсвэрлэх чадвар”, “Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага” MNS7068:2025, Монгол Улсын үндэсний архивын сан хөмрөгийг бүрдүүлэх ач холбогдол, үр дүн, Хөрөнгийн зах зээлийн хөгжил, бодлого зохицуулалт, шинэ бүтээгдэхүүн зэрэг сэдэвт 4 удаагийн цахим сургалтад албан хаагчдаа хамруулсан.

3.2. Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ

- Тайлант хугацаанд 50 иргэнд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө өгсөн. Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тулгамдсан асуудлаар нь ангилж үзвэл:
 - сэтгэл гутралын асуудалтай 10;
 - сэтгэл түгшилттэй 7;
 - гэр бүлийн асуудалтай 4;
 - үл ялих байдалтай (бодол, үйлдэл) 3;
 - мэдрэл сульдалтай 2;
 - нойрны өөрчлөлттэй 4;
 - айдастай 4;
 - биеийн хэлбэрийн өөрчлөлттэй 3;
 - бусад шалтгаантай 13 иргэн байна.
- 2026 оны 5 дугаар сард хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар шинээр ирсэн 29 иргэнд нойргүйдэл илрүүлэх сорил, сэтгэл гутралын болон сэтгэл түгшилтийн сорил хийж, дүгнэлт гаргав. Үүнд:
 - Нойргүйдэл илэрсэн 12 иргэн (20-29 нас), 11 иргэн (30-39 нас);
 - Сэтгэл түгшилтийн завсрын байдалтай 5 иргэн (20-29 нас), 4 иргэн (30-39 нас) байна.;
 - Сэтгэл гутралын байдалтай 1 иргэн (20-29 нас), 2 иргэн (30-39 нас);

- Сэтгэл гутрал, сэтгэл түгшилт нойргүйдэл зэрэг илэрсэн 2 иргэн (30-39 нас) байна.
- СЭМҮТ-ийн сэтгэцийн эмч, сэтгэл засалч Х.Эрхцэцэгтэй хамтран “Эергээр стрессээ тайлах арга зүй” сэдвээр 2026.05.10-ны өдөр цахим сургалт зохион байгуулсан. Сургалтаар стрессийн үед хүний бие махбод болон сэтгэлзүйд гардаг өөрчлөлтүүд, стрессээс урьдчилан сэргийлэх, зөв аргаар даван туулах арга замын талаар мэдээлэл өгч, оролцогчидтой санал солилцсон ба 24 иргэн хамрагдав.
- Awezome сэтгүүлийн сэтгэл зүйн буланд “Холын зайн харилцааны сэтгэл зүй” сэдвээр мэдээллийг бэлтгэн нийтлүүлсэн.

Зураг 1. Цахим сургалтын үеэр



3.3. Хамтын ажиллагаа, төвийн зарим дотоод ажил

2026.05.04-ний өдөр Сөүл хотын Жүнгү дүүргийн цагдаагийн хэлтсийн Олон нийтийн аюулгүй байдал, хэвлэл мэдээллийн тасгийн Гадаад иргэд хариуцсан ажилтан Ким Ён Хвантай уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар Монгол улсын иргэдийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлаар санал солилцсон бөгөөд цаашид Монгол иргэд рүү чиглэсэн контент бүтээх ажлыг хамтран зохион байгуулахаар болсон.

2026.05.12-ны өдөр Монголын эмэгтэйчүүдийн холбооны төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, талууд хамтран 2026.05.30-ны өдөр Солонгос улсад амьдарч буй Монгол хүүхдүүд, эцэг эхчүүдэд зориулсан “Эх үрсийн баяр-2026” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, 10 байгууллагад дэмжлэг хүссэн албан бичгийг хүргүүлсэн.

2026.05.13-ны өдөр БНСУ-ын Тэду хуулийн фирмтэй Монгол Улсын иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгөх, төвөөс зохион байгуулж буй арга хэмжээнд хамтран оролцох чиглэлээр харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.

БНСУ-д ажиллаж буй Монгол Улсын иргэдийн ажлын байрны нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартын хэрэгжилттэй газар дээр нь танилцах үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг нэгтгэн, Элчин сайдын яаманд хүргүүлэв.

Хөдөлмөрийн гэрээний Е-9 визтэй Монгол иргэдийг ажлын байраар хангаж буй ажил олгогчидтой холбогдон талархал илэрхийлэх, санал бодлыг нь сонсох, тогтвортой нөхцөлөөр дахин ирсэн хөдөлмөрийн гэрээт ажилчидтай эргэх холбоо үүсгэх, мэдээллийн сан бүрдүүлэх, нөхцөл байдлыг нь сонсож, ур чадвартай ажилчны Е-7-4 виз болон хөдөлмөрийн харилцаатай холбоотой хууль зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх зорилгоор 136 ажил олгогч 45 ажилчинтай утсаар холбогдов.

Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн тогтолцооны хүрээнд хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирсэн Монгол Улсын иргэдийн 2025 он, 2026 оны 1-4 дүгээр сарын судалгааг нэгтгэн, удирдлагад танилцуулав.

Тогтвортой нөхцлөөр 2024, 2025 онд ирсэн хөдөлмөрийн гэрээт ажилчидтай эргэх холбоо үүсгэсэн мэдээллийг нэгтгэв.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Бауыржанд хөдөлмөрийн гэрээт иргэдтэй “Хариуцлагын гэрээ” байгуулах асуудал, гэрээнд тусгах саналыг нэгтгэж албан бичиг хүргүүлэв.

Хөдөлмөрийн гэрээт ажилчидтай тогтмол эргэх холбоотой ажиллах зорилтын хүрээнд 124 иргэнтэй утсаар холбогдож, нөхцөл байдлыг нь тодруулж, хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн.

Шинээр ирсэн гэрээт ажилчдын судалгаа, ур чадвартай ажилчдын судалгаа, нутаг буцаж буй иргэдийн судалгааны мэдээллийг шинэчилсэн.

- - - оОо - - -